



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг
улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Б.Батцэрэн, Х.Батсүрэн, М.Батсуурь, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам /САИНН/-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам /САИНН/-ын дарга гэх Б.Жагараас 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Улсын дээд шүүхэд хандаж ирүүлсэн хүсэлтдээ:

“Монгол Улсын нэр бүхий иргэд бид Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан эвлэлдэн нэгдэх эрхийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдөр улс төрийн намыг үүсгэн байгуулах Их хурал зарлан Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг албан ёсоор үүсгэн байгуулсан билээ.

Бид 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр бүртгүүлэх хүсэлтээ өгсөн боловч 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 03 дугаар тогтоолоор Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7 дахь заалтыг хангаагүй үндэслэлээр бүртгэхээс татгалзсан.

Манай намын зүгээс Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7 дахь заалтын дагуу бүх гишүүдийн бүртгэлд дахин хяналт тавьж, нэмэлтээр иргэний үнэмлэхний хуулбарыг хавсарган дахин бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа тул Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэж, нийт 274 хуудас материал болон 927 гишүүний бүртгэлийг, иргэний үнэмлэхний хуулбарыг хавсарган ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна”, 9 дүгээр зүйлийн 9.3-т “нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1-д

зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 9.3.7. намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/" гэж заажээ.

Хүсэлт гаргагч Б.Жагараас Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтдээ хавсаргаж, "Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг үүсгэн байгуулсан" гэх 927 гишүүний бүртгэлийг гараар болон компьютероор бичиж, иргэний үнэмлэхний хуулбарын хамт баримтаар ирүүлснийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд регистрийн дугаар буруу 83, өөрийн нэр буруу буюу зөрсөн 1, хаяг зөрсөн, мэдээлэл дутуу 348, нийт 432 иргэний мэдээллийг дутуу болон зөрүүтэй бүрдүүлж ирүүлсэн нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10/2759 тоот албан бичиг, лавлагаагаар тогтоогдлоо.

Түүнчлэн, "Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам"-ын гишүүн гэх 927 иргэний холбоо барих утасны дугаарыг хүсэлт гаргагчаас Улсын дээд шүүхэд ирүүлээгүй тул тухайн иргэд нь "Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам"-ын гишүүн мөн эсэх талаар болон зөвхөн нэг намын харъяалалтай эсэхийг өөрсдөөс нь лавлах боломжгүй болж, "нам нь 801-ээс доошгүй гишүүнтэй байх" хуулийн шаардлагыг шинээр үүсгэн байгуулагдаж буй "Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам" хангаж буй эсэх нь тодорхойгүй, улс төрийн нам үүсгэн байгуулахад тавигдах суурь шаардлагууд хангагдсан эсэх талаар Улсын дээд шүүх дүгнэлт хийх боломжгүй болов.

Энэ тохиолдолд, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг үүсгэн байгуулсантай холбоотой бусад баримтууд нь Улс төрийн намын тухай хуульд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийх шаардлагагүй.

Иймд, Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харъяалалтай байна", 9.3.7-д "намын 801-ээс доошгүй гишүүн" гэж тус тус заасан шаардлагыг хангасан эсэх нь тогтоогдоогүй гэж үзэж, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т "гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харъяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн /бол Улсын дээд шүүх намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана/" гэж заасны дагуу Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

"Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам"-ыг үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргагч нь дээрх зөрчлүүдийг арилгаж, намын гишүүдийн мэдээллийг үнэн зөв, холбогдох утасны дугаарын хамт бүрдүүлснээр дахин хандах эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1.1, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА